

ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ
2023 ОНЫ 3 ДУГААР УЛИРЛЫН ТАЙЛАН

АГУУЛГА

| | |
|---|----|
| НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД..... | 2 |
| 1.1.ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ..... | 2 |
| 1.2. ХӨРВӨХ ЧАДВАР | 3 |
| 1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД | 3 |
| ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ..... | 4 |
| 2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ..... | 4 |
| 2.1.1. Хувьцааны арилжаа | 4 |
| 2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа..... | 6 |
| 2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа..... | 6 |
| 2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа..... | 7 |
| 2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа | 8 |
| 2.1.6.Уул уурхайг бүтээгдэхүүний биржийн арилжаа | 8 |
| 2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ | 9 |
| 2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц | 4 |
| 2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА..... | 50 |
| ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД..... | 50 |
| ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ | 17 |


НЭГДҮГЭЭР БҮЛЭГ: ЗАХ ЗЭЭЛИЙН ХӨГЖЛИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Олон улсын валютын сан, Дэлхийн банкнаас хөгжингүй болон хөгжиж буй орнуудын хөгжлийн түвшнийг үнэлж, тогтоох хүрээнд хөрөнгийн зах зээлийн хөгжлийн голлох үзүүлэлтүүд болох дараах индикаторуудыг оруулсан байдаг: зах зээлийн үнэлгээ, зах зээлийн үнэлгээний ДНБ-д эзлэх хувь, хөрвөх чадвар, хувьцааны индекс.

1.1. ЗАХ ЗЭЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээ 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 10.29 их наяд төгрөг болсон нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2.15 дахин өссөн бөгөөд уг үзүүлэлт ДНБ-ний 19.47 хувьтай тэнцэж байна.

График 1. ДНБ-д харьцуулсан хөрөнгийн зах зээлийн үнэлгээ



Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн үнэлгээг бүрдүүлж байгаа үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 186 компаниас 30 компанийн зах зээлийн үнэлгээ 9.7 их наяд төгрөгийн үнэлгээтэй байгаа нь хөрөнгийн зах зээлийн нийт үнэлгээний 94.35 хувийг бүрдүүлж байна.

Хүснэгт 1. Зах зээлийн үнэлгээ хамгийн өндөр 30 компани


| № | Компанийн нэр | Эзлэх хувь | № | Компанийн нэр | Эзлэх хувь |
|----|---|------------|----|--------------------------------|------------|
| 1 | “ХААН банк” ХК | 20.57% | 16 | “Ард санхүүгийн нэгдэл” ХК | 0.88% |
| 2 | “Худалдаа хөгжлийн банк” ХК | 13.75% | 17 | “Гугал” ХК | 0.88% |
| 3 | “АПУ” ХК | 12.28% | 18 | “Сэнтрал экспресс си ви эс” ХК | 0.85% |
| 4 | “Голомт банк” ХК | 6.48% | 19 | “Монгол шуудан” ХК | 0.77% |
| 5 | “Хас банк” ХК | 5.65% | 20 | “Монложистикс холдинг” ХК | 0.73% |
| 6 | “Тавантолгой ХК | 5.63% | 21 | “Түмэн шувуут” ХК | 0.63% |
| 7 | “Инвекор ББСБ” ХК | 4.25% | 22 | “Газар шим үйлдвэр” ХК | 0.58% |
| 8 | “Төрийн банк” ХК | 3.72% | 23 | “УБ-БҮК” ХК | 0.51% |
| 9 | “МИК холдинг” ХК | 3.02% | 24 | “Тэнгэриг медиа групп” ХК | 0.44% |
| 10 | “Эрдэнэ ресурс девелопмент корпорэйшн” ХК | 3.01% | 25 | “Монос хүнс” ХК | 0.42% |
| 11 | “Говь” ХК | 2.25% | 26 | “Монголын хөрөнгийн бирж” ХК | 0.37% |
| 12 | “Монгол даатгал” ХК | 1.90% | 27 | “Мандал даатгал” ХК | 0.37% |
| 13 | “Сүү” ХК | 1.23% | 28 | “Лэндмн ББСБ” ХК | 0.34% |
| 14 | “Богд банк” ХК | 1.12% | 29 | “Техник импорт” ХК | 0.33% |
| 15 | “Улсын Их Дэлгүүр” ХК | 1.05% | 30 | “Сэндли ББСБ” ХК | 0.33% |

Тайлбар: Зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.

1.2. ХӨРВӨХ ЧАДВАР

Тайлант хугацаанд хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.42 пунктээр буурч, 1.27 хувьд хүрсэн байна. Манай улсын хөрөнгийн зах зээлийн хөрвөх чадвар бага байгаа нь хувьцааны хэт төвлөрөлтэй холбоотой юм. Тухайлбал 2023 оны 3 дугаар улирлын байдлаар ТОП-20 индекст багтах ХК-уудын хувьцааны төвлөрлийг тооцож үзэхэд хэт төвлөрөлтэй буюу нийт хувьцааны 77.53 хувийг 5-аас дээш хувийн хувьцаа эзэмшигчид эзэмшиж байна.

График 2. Хөрвөх чадвар (хувиар)



1.3. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ИНДЕКСҮҮД

“Монголын хөрөнгийн бирж” ХК-аас ТОП-20, MSE-A, MSE-B гэсэн гурван төрлийн хувьцааны үнийн индексүүдийг тооцон гаргадаг. ТОП-20 индексээр зах зээлийн үнэлгээ болон хувьцаа нь идэвхтэй арилжаалагддаг нэр бүхий 20 компанийн, MSE-A болон MSE-B индексээр үнэт цаасны бүртгэлийн I, II ангилалд багтсан компаниудын хувьцааны үнийн индексийг тус тус харуулдаг байна.

Хүснэгт 2. Индексийн үзүүлэлт

| Индекс | 2022.III | 2023.III | Өөрчлөлт |
|--------|-----------|-----------|----------|
| ТОП 20 | 34,024.26 | 35,436.88 | +4.15% |
| MSE A | 12,098.54 | 15,249.91 | +26.05% |
| MSE B | 11,972.15 | 12,197.78 | +1.88% |

Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

ТОП-20 индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 40,386.51 нэгж, доод үзүүлэлт 34,231.87 нэгж, дундаж үзүүлэлт 36,796.5 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1,412.62 нэгжээр буюу 4.15 хувиар өсөж, **35,436.88** нэгж болсон байна.

MSE-A индексийн дээд үзүүлэлт тайлант хугацааны байдлаар 19,652.35 нэгж, доод үзүүлэлт 14,088.84 нэгж, дундаж үзүүлэлт 15,938.19 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3,151.37 нэгжээр буюу 26.05 хувиар өсөж, **15,249.91** нэгж болсон байна.

Харин MSE-B индексийн дээд үзүүлэлт 12,917.95 нэгж, доод үзүүлэлт 11,636.34 нэгж, дундаж үзүүлэлт 12,402.27 нэгж байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 225.63 нэгжээр буюу 1.88 хувиар өсөж, **12,197.78** нэгж болсон байна.


ХОЁРДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ, НИЙЛҮҮЛЭЛТ

2.1. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН НИЙЛҮҮЛЭЛТ

2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 654.55 тэрбум төгрөгийн үнэт цаасны арилжаа хийгдсэнээс 614.2 тэрбум төгрөгийн арилжаа арилжаа эрхлэх байгууллагаар, 40.35 тэрбум төгрөгийн арилжаа хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар дамжуулан хийгдсэн байна.

Тайлант хугацаанд хувьцааны арилжаа түлхүү явагдсан бөгөөд нийт үнэт цаасны арилжааны 71.35 хувийг хувьцаа, 14.84 хувийг компанийн өрийн хэрэгсэл, 6.98 хувийг хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн, 6.83 хувийг хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа тус тус эзэлж байгаа бөгөөд нийт үнэт цаасны арилжааны хэмжээ өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 дахин өссөн үзүүлэлттэй байна.

График 3. Үнэт цаасны арилжааны хэмжээ (бүтээгдэхүүний төрөл, хувиар)




Харин Хөдөө аж ахуйн биржээр тайлант хугацаанд 164 удаагийн цахим арилжаа зохион байгуулагдсан ба нийт 824.5 тэрбум төгрөгийн бараа бүтээгдэхүүн арилжаалагдсан бол Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр 63 удаагийн арилжаа зохион байгуулагдаж нийт 2.02 их наяд төгрөгийн уул уурхайн бүтээгдэхүүн арилжаалагдсан байна.

2.1.1. Хувьцааны арилжаа

График 4. Хувьцааны арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд нийт 467.02 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа хийгдсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 3.1 дахин өссөн үзүүлэлттэй байна.

Үүнээс хувьцааны анхдагч зах зээлд нийт 335.95 тэрбум төгрөгийн, хоёрдогч зах зээлд нийт 131.07 тэрбум төгрөгийн хувьцааны арилжаа тус тус хийгдсэн байна.



Хоёрдогч зах зээл дээрх хувьцааны арилжааг арилжаа эрхлэх байгууллага дээр бүртгэлтэй, арилжааны хэмжээгээрээ тэргүүлэгч 30 компанийн арилжааны мэдээллийг үнийн дүнгээр харуулбал:

Хүснэгт 3. Арилжааны хэмжээ хамгийн өндөр 30 компанийн арилжааны үнийн дүн (тэрбум төгрөгөөр)

| № | Компанийн нэр | Үнийн дүн | № | Компанийн нэр | Үнийн дүн |
|-------------|---|-----------|----|---------------------------------|---------------|
| 1 | “Инвескор ББСБ” ХК | 20.49 | 16 | “Ард Даатгал” ХК | 1.48 |
| 2 | “ХААН” ХК | 14.7 | 17 | “Монос Хүнс” ХК | 1.35 |
| 3 | “Худалдаа хөгжлийн Банк Банк” ХК | 13.2 | 18 | “Төрийн Банк” ХК | 1.34 |
| 4 | “Голомт Банк” ХК | 11.13 | 19 | “Түмэн шувуут” ХК | 1.25 |
| 5 | “АПУ” ХК | 10.7 | 20 | “Ард Кредит ББСБ” ХК | 1.24 |
| 6 | “Богд Банк” ХК | 6.73 | 21 | “Мандал Даатгал” ХК | 1.03 |
| 7 | “Монголын хөрөнгийн бирж” ХК | 6.52 | 22 | “Газар шим үйлдвэр” ХК | 0.83 |
| 8 | “Ард санхүүгийн нэгдэл” ХК | 5.99 | 23 | “Монгол Шуудан Бодь Даатгал” ХК | 0.67 |
| 9 | “Говь” ХК | 4.04 | 24 | “Хорин хоёрдугаар бааз” ХК | 0.66 |
| 10 | “Атар-Өргөө” ХК | 4.00 | 25 | “Хас банк” ХК | 0.65 |
| 11 | “Сентрал экспресс Си Ви Эс” ХК | 3.96 | 26 | “ЛэндМН ББСБ” ХК | 0.62 |
| 12 | “Таван Толгой” ХК | 3.07 | 27 | “Сүү” ХК | 0.59 |
| 13 | “Сэндли ББСБ” ХК | 2.46 | 28 | “Бодь даатгал” ХК | 0.55 |
| 14 | “Эрдэнэ Ресурс Девелопмент Корпорэйшн” ХК | 2.26 | 29 | “Крипто Үндэстэн” ХК | 0.53 |
| 15 | “Талх Чихэр” ХК | 2.23 | 30 | “Тэнгэрлиг медиа групп” ХК | 0.51 |
| НИЙТ | | | | | 124.86 |

2.1.1.1. Багцын арилжаа

Тайлант хугацаанд нийт 17 хувьцаат компанийн 78.32 сая ширхэг буюу 51.31 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий багцын арилжаа хийгдсэн нь нийт хувьцааны хоёрдогч зах зээлийн арилжааны 39.15 хувийг эзэлж байна.

Хүснэгт 4. Багцын арилжаа хийгдсэн компаниуд

| № | Үнэт цаасны нэр | Арилжаалагдсан ширхэг (мянган ширхэг) | Үнийн дүн (тэрбум төгрөг) |
|-----|--------------------------------|---------------------------------------|---------------------------|
| 1. | “Ард санхүүгийн нэгдэл” ХК | 321.71 | 1.03 |
| 2. | “Хорин хоёрдугаар бааз” ХК | 213.42 | 0.50 |
| 3. | “Ард Даатгал” ХК | 933.76 | 0.85 |
| 4. | “АПУ” ХК | 4,339.09 | 5.00 |
| 5. | “Бодь Даатгал” ХК | 4,033.58 | 0.50 |
| 6. | “Богд банк” ХК | 35,159.93 | 3.75 |
| 7. | “Сентрал экспресс Си Ви Эс” ХК | 8,413.46 | 1.99 |
| 8. | “Голомт Банк” ХК | 3,409.12 | 4.32 |
| 9. | “Говь” ХК | 7,500.00 | 2.63 |
| 10. | “Инвескор ББСБ” ХК | 3,101.24 | 16.85 |
| 11. | “ХААН Банк” ХК | 1,600.00 | 1.84 |
| 12. | “Мандал говь импекс” ХК | 52.61 | 0.03 |
| 13. | “Мандал Даатгал” ХК | 6,487.29 | 0.42 |
| 14. | “Монголын хөрөнгийн бирж” ХК | 1,691.34 | 0.25 |
| 15. | “Худалдаа Хөгжлийн Банк” ХК | 365.42 | 11.09 |
| 16. | “Өлзий-Дундговь” ХК | 73.83 | 0.01 |

| | | |
|--------------|------------------|--------------|
| 17. “Сүү” ХК | 625.00 | 0.25 |
| ДҮН | 78,320.81 | 51.31 |


Эх сурвалж: “Монголын хөрөнгийн бирж” ХК

2.1.2. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа

График 5. Компанийн өрийн хэрэгслийн арилжаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд компанийн өрийн хэрэгслийн нийт арилжаа 97.12 тэрбум төгрөг байгаа нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 7.62 хувиар буурсан үзүүлэлт юм.

Компанийн өрийн хэрэгслийн анхдагч зах зээлд нийт 75.5 тэрбум төгрөг, хоёрдогч зах зээлд нийт 21.62 тэрбум төгрөгийн арилжаа тус тус хийгдсэн байна.



Хороо тайлант хугацаанд 6 компанийн гаргаж буй өрийн хэрэгслийг бүртгэсэн. Үүнд:

- “Сэндли ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 85,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Бизнес-Инвест девелопмент ББСБ” ХХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 80,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “ХААН банк” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 170,000 хүртэл ширхэг, нэг бүр нь 100 ам.долларын нэрлэсэн үнэ бүхий 250,000 хүртэл ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Ашид капитал ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 200,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- “Лэндмн ББСБ” ХК-ийн нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 90,000 ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.
- Нийслэлийн засаг даргын хөтөлбөрийн хүрээнд нийтэд санал болгон гаргаж буй нэг бүр нь 100,000 төгрөгийн нэрлэсэн үнэтэй, 5,000,000 хүртэл ширхэг өрийн хэрэгслийг бүртгэсэн.

2.1.3. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа

Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль батлагдсанаас хойш 2023 оны 3 дугаар улирлын байдлаар нийт 37 компани хөрөнгө оруулалтын менежментийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл авсан байна.


Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 1 компанид хөрөнгө оруулалтын сангийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгож, 1 компанийн хамтын хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэн байна. Үүнд:

- “Ашид ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулсан “Ашид арвижих” хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сан нэгж эрхийн анхдагч зах зээлд арилжих ажиллагааг амжилттай зохион байгуулж, 10,121,444 ширхэг нэгж эрхийг нэг бүрийг

100 (нэг зуун) төгрөгөөр олон нийтэд санал болгон арилжаалж, нийт 1,012,144,400 төгрөгийг татан төвлөрүүлсэн байна.

- “Инвекор ассет менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Инвекор Глобал Кью” хамтын биржээр арилжаалагддаг хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичиг болон сангийн нэгж эрхийн танилцуулгыг бүртгэсэн.

График 6. Хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн анхдагч зах зээлд нийт 1.01 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн бол хоёрдогч зах зээлд нийт 44.67 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж нийт 45.68 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

График 7. Тайлант хугацаанд хийгдсэн хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн арилжааны задаргаа (тэрбум төгрөгөөр)

Тайлант хугацаанд хамтын хөрөнгө оруулалтын сангийн нэгж эрхийн хоёрдогч зах зээлд нийт 44.67 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэнээс хамтын хаалттай хөрөнгө оруулалтын сангаар 5.34 тэрбум төгрөгийн арилжаа, хамтын нээлттэй хөрөнгө оруулалтын сангаар 33.33 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн нь тус тус нийт арилжааны 11.9 болон 88.1 хувийг бүрдүүлж байна.




2.1.4. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа

Тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос 7 компанид хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосноос 4 компанийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна. Үүнд:

- 2023 оны 256, 257, 403 дүгээр тогтоолоор тус тус "Омни ассет" ХХК, "ҮЦСК актив зургаа" ХХК, "МИК актив гучин дөрөв" ХХК-д хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгосон бол 88, 151, 181, 209 дүгээр тогтоолоор тус тус “Бэрс Эй Би Эс плас ТЗК” ХХК, “ҮЦСК Актив тав ТЗК” ХХК, "Бичил Эй Би Эс плас ТЗК" ХХК, "МИК актив гучин гурав ТЗК" ХХК-ийн хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасыг бүртгэсэн байна.

График 8. Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны арилжаа (тэрбум төгрөгөөр)



Тайлант хугацаанд хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны анхдагч зах зээлийн арилжаагаар 29 тэрбум төгрөгийн арилжаа, хоёрдогч зах зээлд нийт 15.73 тэрбум төгрөгийн арилжаа хийгдэж, нийт 44.72 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

2.1.5. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа

Тайлант хугацаанд Хөдөө аж ахуйн бирж нь 164 удаагийн цахим арилжаа зохион байгуулан 993 хэлцлээр нийт 824.6 тэрбум төгрөгийн үнэ бүхий бараа, түүхий эдийн арилжаа хийсэн байна. Энэ нь өмнөх оны мөн үеэс 209.6 тэрбум төгрөгөөр буюу 20.3 хувиар буурсан үзүүлэлт бөгөөд дараах төрлийн бүтээгдэхүүнүүд арилжаалагдсан байна. Үүнд:

Зураг 1. Хөдөө аж ахуйн биржийн арилжаа



Хүснэгт 5. Хөдөө аж ахуйн биржийн арилжааны дүн (бүтээгдэхүүний төрлөөр)

| | | |
|----------------------|---------------------------|---|
| Ямааны ноолуур | 739,502,146,800.00 | Нийт арилжааны дийлэнх хувийг буюу 89.68 хувийг ямааны ноолуур, 5.62 хувийг завод ноос, 2.47 хувийг тосны ургамал, 1.35 хувийг хонины ноос, 0.86 хувийг тэмээний ноос тус тус эзэлж байгаа бол үлдсэн хэсэг болох 0.02 хувийг бодын хөөвөр болон арьс шир бүрдүүлж байна. |
| Хонины ноос | 11,116,757,000.00 | |
| Завод ноос | 46,373,669,000.00 | |
| Тэмээний ноос | 7,066,250,000.00 | |
| Тосны ургамал (рапс) | 20,332,900,000.00 | |
| Бодын хөөвөр | 168,500,000.00 | |
| Арьс шир | 6,600,000.00 | |
| Нийт | 494,905,973,000.00 | |

2.1.6. Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа

Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль 2023 оны 06 дугаар сарын 30-ны өдрөөс хэрэгжиж эхэлсэн бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооноос “Монголын хөрөнгийн бирж” ХК-д уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг олгосны авсны үндсэн дээр тус бирж уул уурхайн бүтээгдэхүүний арилжааг зохион байгуулж байна.

Дээрх хууль хэрэгжиж эхэлснээс хойш 2023 оны 3 дугаар улирлын байдлаар 54 удаагийн арилжаагаар 4.45 сая тонн нүүрс 2.02 их наяд төгрөгөөр, 9 удаагийн арилжаагаар

100,600 тонн төмрийн баяжмал 33.59 тэрбум төгрөгөөр тус тус арилжаалагдаж нийт 63 удаагийн арилжаагаар 4.55 сая тонн уул уурхайн бүтээгдэхүүнийг 2.05 их наяд төгрөгөөр арилжаалагдсан байна.


График 9. Нийт арилжаалагдсан нүүрсний хэмжээ (төрөл, ангилал, хувиар)



Тайлант хугацаанд нийт 6 төрлийн 4.45 сая тонн нүүрс арилжаалагдсанаас 1/3 коксжих нүүрс 36.7 хувийг, баяжуулсан коксжих нүүрс 8.8 хувийг, баяжуулсан дунд зэрэг үнстэй хагас хатуу коксжих нүүрс 1.8 хувийг, баяжуулсан сул коксжих нүүрс 0.6 хувийг, дэгдэмхий бодис дунд, коксжих нүүрс 48.5 хувийг, эрчим хүчний нүүрс 3.7 хувийг тус тус эзэлж байна

График 10. . Нийт арилжаалагдсан төмрийн хэмжээ (төрөл, ангилал, хувиар)

Тайлант хугацаанд нийт 100,600 тонн төмрийн баяжмал арилжаалагдсаны 86.5 хувь Fe-65%-ийн агууламжтай, 13.5 хувь нь Fe-58%-ийн агууламжтай байна.




2.2. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ЭРЭЛТ

Тайлант хугацаанд 107,948 шинэ данс, 51,509 холболтын данс шинээр нээгдэж өссөн дүнгээр нийт 2,554,238 данс, 619,410 холболтын данс “ҮЦТХТ” ХХК-д бүртгэлтэй байна.

2.2.1. Хөрөнгө оруулагчдын бүтэц

График 11. Гадаад дотоодын хөрөнгө оруулагчдын арилжааны үнийн дүнд эзлэх хувь



Тайлант хугацаанд нийт арилжаанд дотоодын иргэний хийсэн арилжаа 93.65 тэрбум төгрөг (53.7 хувь), дотоодын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 76.5 тэрбум төгрөг (43.88 хувь), гадаадын иргэний хийсэн арилжаа 1.43 тэрбум төгрөг (0.82 хувь), гадаадын аж ахуйн нэгжийн хийсэн арилжаа 2.8 тэрбум төгрөг (1.6 хувь)-ийг тус тус эзэлж нийт 174.3 тэрбум төгрөгийн арилжаа хийгдсэн байна.

Эх сурвалж: "Монголын үнэт цаасны клирингийн төв" ХХК

2.3. БИРЖИЙН БУС ЗАХ ЗЭЭЛИЙН ҮЙЛ АЖИЛЛАГАА

Санхүүгийн зохицуулах хорооны зүгээс Биржийн бус зах зээлийн зохицуулалтыг орчныг тодорхой болгохоор “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-ыг баталсан. Биржийн бус зах зээл нь биржийн зах зээлтэй харьцуулахад мэргэжлийн хөрөнгө оруулагчид оролцдог онцлогтой бөгөөд энэ нь үнэт цаас гаргах гэж буй компаниудад тавигдах шалгуур нь харьцангуй бага байх, үнэт цаас гаргах цаг хугацаа, зардал хэмнэх зэрэг олон давуу талыг олгож байна.

Биржийн бус зах зээлийн үйл ажиллагаа эхэлсэн өдрөөс 2023 оны 3 дугаар улирал хүртэлх хугацаанд биржийн бус зах зээлд нийт 86 компанийн нийт 2.25 их наяд төгрөгийн үнийн дүн бүхий 126 өрийн хэрэгсэл гарсан бөгөөд 1.63 их наяд төгрөгийг амжилттай татан төвлөрүүлсэн байна. Үүнээс тайлант хугацаанд 49 үнэт цаас гаргагчийн 844.8 тэрбум төгрөгийн үнийн дүн бүхий, 128 транч өрийн хэрэгслийг бүртгэсэн байна.

График 12. Тайлант хугацаанд ББЗЗ-д бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар ангилсан тоон мэдээлэл (хувиар)

Тайлант хугацаанд бүртгэгдсэн нийт өрийн хэрэгслийн татан төвлөрүүлэхээр зарласан дүнг үнэт цаас гаргагчийн үйл ажиллагааны салбараар нь ангилбал уул уурхай 10.0 хувь, банк бус 31.0 хувь, үл хөдлөх 14.0 хувь, санхүү 11.0 хувь, гадаад худалдаа борлуулалт 12.0 хувь, үйлдвэрлэл, худалдаа 12.0 хувь, бусад салбар 10.0 хувийг бүрдүүлж байна.



ГУРАВДУГААР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛИЙН ОРОЛЦОГЧИД

Өнөөдрийн байдлаар үнэт цаасны зах зээл дээр Үнэт цаасны зах зээлийн тухай хууль, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаасны тухай хууль, Компанийн тухай хууль, Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль, Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хууль, Инновацийн тухай хууль зэрэг хуулиуд хүчин төгөлдөр мөрдөгдөж байна. Эдгээр хууль болон бусад холбогдох дүрэм, журам, зааврын хэрэгжилтэд хяналт тавих, санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хөрөнгө оруулагчдын эрх ашгийг хамгаалах чиг үүргийг Санхүүгийн зохицуулах хороо хэрэгжүүлж байна.

Дээрх хууль тогтоомжийн хүрээнд тайлант хугацаанд Санхүүгийн зохицуулах хорооноос тусгай зөвшөөрөл болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй 288 зохицуулалттай этгээд байна.

Хүснэгт 6. Үнэт цаасны зах зээлд оролцогчид

| № | Үйл ажиллагааны төрөл | Тоо |
|--|---|-----------------|
| Тусгай зөвшөөрөлтэй үйл ажиллагаа эрхлэгч | | |
| 1 | Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага | 3 |
| 2 | Үнэт цаасны тооцооны байгууллага | 2 ¹ |
| 3 | Үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн байгууллага | 1 |
| 4 | Үнэт цаасны төлбөрийн байгууллага | 1 ² |
| 5 | Хөрөнгө оруулалтын менежментийн компани | 37 |
| 6 | Хамтын хөрөнгө оруулалтын сан /хаалттай, нээлттэй/ | 5 |
| 7 | Кастодиан банк | 3 |
| 8 | Үнэт цаасны компани | 52 |
| | Брокер | 51 |
| | Үүнээс: | |
| | Гадаад улсын үнэт цаасны зах зээлд үнэт цаас худалдах, худалдан авахад зуучлах үйл ажиллагаа эрхлэгч | 16 |
| | Номинал дансаар дамжуулан харилцагчдад мөнгөн хөрөнгийн орлого, зарлагын гүйлгээний үйлчилгээний үйлчилгээ үзүүлэгч | 15 |
| | Дилер | 34 |
| | Андеррайтер | 22 ³ |
| | Хөрөнгө оруулалтын зөвлөх үйлчилгээ үзүүлэгч | 20 |
| 9 | Хөрөнгө итгэмжлэн удирдагч | 8 |
| 10 | Барьцаат үнэт цаасны хөрөнгийн багцын бүртгэлийг хянагч | 1 |
| 11 | Хөрөнгөөр баталгаажсан үнэт цаас гаргах тусгай зөвшөөрөлтэй компани | 56 ⁴ |
| 12 | ХАА-н гаралтай бараа, түүхий эдийн биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага | 1 |
| 13 | ХАА-н биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага | 10 |
| 14 | Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх байгууллага | 1* |
| 15 | Санхүүжих чадавхын зэрэглэл тогтоох байгууллага | 1 |
| Бүртгэлтэй хөндлөнгийн мэргэжлийн үйлчилгээ үзүүлэгч байгууллагууд | | |
| 16 | ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэгч байгууллага | 66 ⁵ |
| | Аудитын үйлчилгээ үзүүлэгч байгууллага | 48 |
| | Хөрөнгийн үнэлгээний үйлчилгээ үзүүлэгч байгууллага | 24 |
| 17 | ҮЦЗЗ-д оролцогчид хууль зүйн зөвлөгөө үзүүлэгч байгууллага | 41 |
| Нийт (ТЗ болон бүртгүүлсний үндсэн дээр үйл ажиллагаа эрхэлж буй компаниудын тоо) | | 288 |

Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй нийт 186 ХК байна. Мөн Хорооны 2015 оны 06-р сарын 10-ны өдрийн 273 дугаар тогтоолоор “Монголын үнэт цаасны арилжаа эрхлэгчдийн холбоо” ГҮТББ-ыг, 2015 оны 10-р сарын 13-ны өдрийн 379 дүгээр тогтоолоор “Монголын хөрөнгийн бирж” ХК-ийг өөрийгөө зохицуулах байгууллагаар тус тус бүртгэсэн.

¹ Тус тоонд үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллага болох “Улаанбаатар Үнэт Цаасны Бирж” ХК болон “МУЦКТ” ХХК орсон болно.

² “ҮЦТХТ” ХХК нь үнэт цаасны төвлөрсөн хадгаламжийн болон төлбөрийн үйл ажиллагааг үзүүлдэг.

³ Тус тоонд андеррайтерийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөлтэй 2 банк /“Голомт банк” ХК, “Тээвэр Хөгжлийн банк” ХХК/ орсон болно.

⁴ Тус тоонд “МИК ОССК” ХХК-33, “ҮЦСК” ХХК-6, “Носк тав ТЗК” ХХК-5, нээлттэй хүрээнд ХБҮЦ гаргасан 10 ТЗК, хаалттай хүрээнд гаргасан 1 ТЗК тус тус орсон.

⁵ ҮЦЗЗ-д оролцогчид аудитын үйлчилгээ, хөрөнгийн үнэлгээ үзүүлэх үйлчилгээг зэрэг үзүүлдэг 6 компани байна.

Хүснэгт 7. Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагад бүртгэлтэй ХК-ийн тоо болон зах зээлийн үнэлгээ

| Үнэт цаасны арилжаа эрхлэх байгууллагын нэр | Бүртгэлтэй ХК-ийн тоо | Зах зээлийн үнэлгээ 2023.III |
|---|-------------------------------|--|
| 1) “Монголын хөрөнгийн бирж” ХК -100 хувь төрийн өмчит -Төрийн өмчийн оролцоотой -Төрийн өмчийн оролцоогүй | 185 16 11 158 | 10,288,846,385,793.00 ₮ (Тус биржийн зах зээлийн үнэлгээнд 100 хувь төрийн өмчит компанийн үнэлгээ ордоггүй болно.) |
| 2) “Улаанбаатар үнэт цаасны бирж” ХК | 1 | 1,951,768,950.00 ₮ |
| 3) “Чингис хаан хөрөнгийн бирж” ХХК | - | - |

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. ҮНЭТ ЦААСНЫ ЗАХ ЗЭЭЛ ДЭЭР САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНООС АВЧ ХЭРЭГЖҮҮЛСЭН ОНЦЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Санхүүгийн зохицуулах хорооноос 2023 оны 3 дугаар улирлын байдлаар Монгол Улсын хөрөнгийн зах зээлийн зохицуулалтын орчныг боловсронгуй болгох, бүтээгдэхүүн, үйлчилгээний нэр төрлийг нэмэгдүүлэх чиглэлд голчлон анхаарч дараах ажлуудыг хийж гүйцэтгэлээ. Үүнд:

4.1. Хууль эрх зүйн зохицуулалт

Монгол Улсын Сангийн сайдын 2021 оны 04 дүгээр сарын 05-ны өдөр 52 дугаар тушаалаар шинэчлэн баталсан “Хөрөнгийн зах зээлийн холбогдох хууль эрх зүйн орчин шаардлагатай нэмэлт, өөрчлөлт оруулах үүрэг бүхий” ажлын хэсгийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалыг боловсруулж, Сангийн сайд болон Хууль зүй, дотоод хэргийн сайдаар батлуулсан. Түүнчлэн уг ажлын хэсгийн зүгээс Үнэт цаасны зах зээлийн тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулах хуулийн төсөл болон тус хуулийг дагалдан өргөн баригдах Хөрөнгө оруулалтын сангийн тухай хууль, Компанийн тухай хууль, Аж ахуй нэгжийн орлогын албан татварын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг эцэслэн боловсруулж, улмаар Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, зөвшөөрөл авсны үндсэн дээр 2023 оны Улсын Их Хурлын намрын ээлжит чуулганд өргөн мэдүүлэхээр ажиллаж байна.

Улсын Их Хурлаас 2023 оны 01 дүгээр сард Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны тухай хуулийг баталсан. Үүнтэй холбогдуулан “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны худалдах, худалдан авах үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээг тогтоох, хэлцэл хийхэд баримтлах журам”, “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагааны зохистой харьцааны шалгуур үзүүлэлт болон хязгаарлалтыг тогтоох, түүнд хяналт тавих журам”, “Хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх журам” болон хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны зээл, зээлийн үйл ажиллагаанд баримтлах шаардлагыг Монголбанкны ерөнхийлөгч, Санхүүгийн зохицуулах хорооны даргын 2023 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн А-164/386, А-165/385 дугаар хамтарсан тушаалын дагуу баталсан. Дээрх журмууд батлагдсанаар хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үнэт цаасны зах зээл, мөнгөний зах зээл дээрээс худалдан авч, худалдаж болох үнэт цаас, санхүүгийн хэрэгслийн төрөл, хэмжээ, зохистой харьцааны шалгуур үзүүлэлт, хөрөнгө оруулалтын төрөлжсөн банкны үйл ажиллагаанд хийх хязгаарлалт, тавигдах шаардлага, хяналт шалгалттай холбоотой нарийвчилсан зохицуулалтууд бий болох юм.

4.2. Хамтын ажиллагаа

Санхүүгийн зохицуулах хороо Монголын Үндэсний Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимтай хамтран ТОП-100 аж ахуйн нэгжүүдийг хөрөнгийн зах зээлээс санхүүжилт татах боломжийг нэмэгдүүлэх зорилгоор “ТОП-100 аж ахуйн нэгжийн хөрөнгийн зах зээл дэх оролцоог өсгөх арга хэмжээний хөтөлбөр”-ийг 2023 оны 05 дугаар сарын 22-ны өдөр баталсан.

Энэхүү хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд хөрөнгийн зах зээлд IPO хийх, компанийн бонд гаргахад тавих нөхцөл, шаардлага, цаг хугацаа, өртгийг бууруулж, IPO хийхэд хөрөнгийн үнэлгээ хийлгэхийг шаардахгүй байх, мөн нээлттэй, хаалттай хүрээнд бонд гаргахад барьцаа, батлан даалт шаардахгүй байх гэх зэргээр үнэт цаас гаргах ажиллагааг хялбаршуулах зохицуулалтуудыг “Үнэт цаасны бүртгэлийн журам”, “Өрийн хэрэгслийн бүртгэлийн журам” болон “Биржийн бус зах зээлийн үйл ажиллагааны журам”-д тус тус тусгаж, нэмэлт, өөрчлөлт оруулахаар ажиллаж байна. Түүнчлэн ТОП-100 аж ахуйн нэгжүүдэд IPO хийх, компанийн бонд гаргахтай холбоотой холбогдох дүрэм, журмын талаарх ойлголт, мэдээллийг өгөх сургалт, арга хэмжээг шат дараалалтай зохион байгуулахаар төлөвлөн ажиллаж байна.

Уг хөтөлбөрийн хүрээнд ТОП-100 аж ахуйн нэгжүүд нь IPO хийх замаар нээлттэй хувьцаат компани болох, компанийн бонд гаргаж санхүүжилт татах замаар хөрөнгийн зах зээлд оролцооноор бизнесийн үйл ажиллагаагаа өргөжүүлж, ашиг, орлогоо өсгөх, компанийн нэр хүндээ өсгөх, урт хугацааны хямд санхүүжилтийн эх үүсвэр татах, компанийнхаа засаглал, мэдээллийн ил тод байдлыг сайжруулах зэрэг чухал ач холбогдолтой юм.

4.3. Уул уурхайн бүтээгдэхүүний бирж

Улсын Их Хурлаас өнгөрсөн оны 12 дугаар сард Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн тухай хуулийг баталсан бөгөөд тус хуулийн 17 дугаар зүйлийн 17.2, 17.3, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.3-г тус тус заасан холбогдох журмуудыг Хороо батлахаар заасан. Үүний дагуу журмын төслүүдийг эцэслэн боловсруулж, Хорооны хуралдаанаар хэлэлцүүлж 2023 оны 06 дугаар сарын 02-ны өдрийн Хорооны 186, 187, 189 дүгээр тогтоолоор тус тус “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн болон биржийн арилжааны зуучлагч /брокер/-ийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрөл олгох, түүнд хяналт тавих журам”, “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжаа төлбөр, тооцоо хийх ерөнхий журам”, “Үүсмэл санхүүгийн хэрэгсэл гаргагчид тавих нөхцөл, шаардлага, шалгуур болон үүсмэл санхүүгийн хэрэгслийн стандарт, түүнийг арилжих журам” -ын төслүүдийг баталсан. Мөн Хорооны 2023 оны 06 дугаар сарын 12-ны өдрийн 318, Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны А/231 дугаар хамтарсан тушаалын дагуу “Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн арилжааны болон ханшийн мэдээллийн нэгдсэн сан бүрдүүлэх, ашиглах, мэдээллийг нийтэд хүргэх журам”-ыг баталсан бөгөөд Санхүүгийн зохицуулах хорооны 2023 оны 385 дугаар тогтоолоор Уул уурхайн бүтээгдэхүүний биржийн үйл ажиллагаа эрхлэх тусгай зөвшөөрлийг “Монголын хөрөнгийн бирж” ХК-д олгосон.

Уул уурхайн бүтээгдэхүүний биржээр арилжаалах бүтээгдэхүүний нэр төрөл, ангиллыг Засгийн газрын 2023 оны 223 дугаар тогтоолоор баталж, боловсруулаагүй нүүрс, баяжуулсан нүүрс, төмөр болон хайлуур жоншны хүдэр, баяжмалыг арилжаалахаар шийдвэрлэсэн.

Үүний дагуу уул уурхайн бүтээгдэхүүний бирж болох “Монголын хөрөнгийн бирж” ХК-аас төмөр болон хайлуур жоншны хүдэр, баяжмалын арилжааны гэрээний стандартыг тогтоохтой холбоотой журмыг боловсруулж, тус Хорооны 2023 оны 458, 465 дугаар тогтоолоор журам мөрдүүлэх зөвшөөрөл авсан. Уул уурхайн бүтээгдэхүүн биржээр дамжуулан арилжаалагдаж эхэлснээр арилжаа олон нийтэд нээлттэй, шударга, ил тод зохион байгуулагдаж, бүтээгдэхүүн үнийн өсөлттэй арилжаалагдах, экспортыг нэгдсэн бодлогоор хангах зэрэг олон давуу тал бий болсон.

ҮНЭТ ЦААСНЫ ГАЗАР

---o-0-o---